

“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын
04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 5

ХӨНДЛӨНГИЙН ХАРААТ БУС АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫГ СОНГОХ ЖУРАМ



Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, үйл ажиллагаанд нь үнэлэлт өгөх, аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Компани нь “Аудитын тухай” хуулийн 10.1.1 болон 10.1.4-т заасны дагуу жилийн санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх үүрэг хүлээсэн учраас жилийн санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын байгууллагыг сонгохдоо энэхүү журмыг баримтална.

Хоёр. Хөндлөнгийн аудиторыг сонгох

- 2.1 Хөндлөнгийн аудиторыг сонгохдоо дараах нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Үүнд:
 - 2.1.1 Тухайн аудитын байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон аудитор нь компанийн эрх бүхий албан тушаалтан болон санхүүгийн ажилтантай холбогдох этгээд биш байх;
 - 2.1.2 Тухайн аудитын байгууллага нь банк бус санхүүгийн үйлчилгээ эрхлэх компанийн нягтлан бодох бүртгэл, холбогдох СТОУС-ын талаар мэдлэг, туршлагатай аудиторудтай байх;
 - 2.1.3 Тухайн аудитын байгууллага нь компанид өмнө нь өөр үйлчилгээ үзүүлээгүй байх;
- 2.2 Хараат бус аудитын байгууллагыг сонгохдоо дараах журмыг баримтална. Үүнд:
 - 2.2.1 Санхүүгийн зохицуулах хорооноос эрх авсан аудитын байгууллагуудын жагсаалт, жагсаалтад орсон компани тус бүрийн танилцуулгатай дотоод аудитор болон холбогдох газар нэгжийн удирдлага танилцаад, сонгож болох аудитын байгууллагын удирдах албан тушаалтантай биечлэн уулзаж, энэ журмын 2.1-д заасан нөхцөл байдлыг хангаж буй аудитын байгууллагын талаар санал дүгнэлт бэлдэж, тэдгээрээс ирүүлсэн үйлчилгээ үзүүлэх талаарх албан захидлын /үнийн саналыг тусгасан/ хамтаар ТУЗ-ийн аудитын хороонд хүргүүлнэ.
 - 2.2.2 ТУЗ-ийн аудитын хороо нь аудитын байгууллагыг сонгох саналаа ТУЗ-ийн хуралдаанд танилцуулах бөгөөд ТУЗ-ийн хурлаас хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох шийдвэр гаргаж, түүнтэй байгуулах гэрээний төслийг батална.
- 2.3 Хөндлөнгийн аудитын байгууллагатай байгуулах гэрээнд аудитын үйл ажиллагаатай холбогдуулж харилцан хүлээх үүрэг, хариуцлага, ажлын хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг заасан байна.

Гурав. Аудитын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

- 3.1 Аудитын үйлчилгээний тухай гэрээ байгуулсны дараа дараах байдлаар аудитын байгууллагын үйл ажиллагаанд бүх талаар дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

- 3.1.1 Холбогдох олон улсын стандартад нийцүүлэн гаргасан санхүүгийн тайланг аудиторт шалгуулахаар хүлээлгэн өгөх;
- 3.1.2 Аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах;
- 3.1.3 Аудиторын шаардсан баримт, мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх;
- 3.1.4 Байгууллагын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэл, тайланд стандартын дагуу зөв тусгасан тухай, мөн эдгээртэй холбогдох баримт, материал, тайлбарыг бүрэн танилцуулсан, энэ талаар үүсч болох хариуцлагыг хүлээх тухайгаа нотолсон тодорхойлолтыг аудиторт гаргаж өгөх.
- 3.1.5 Аудиторын хүссэн шаардлагатай нотлох баримтыг гуравдагч этгээдээс гаргуулж өгөх.
- 3.2 Энэ журмын 3.1-д заасныг хэрэгжүүлэхийн тулд компанийн эрх бүхий албан тушаалтан болон бусад бүх ажилтнууд аудиторын шаардсан бүхий л баримт мэдээллийг тухай бүр гаргаж толилуулах үүрэг хүлээнэ.
- 3.3 Компанийн ЭБАТ болон ажилтнууд энэ журмын 3.1-д заасныг хэрэгжүүлэлгүй аудитын үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд аудитор нь дотоод аудиторт гомдол гаргах эрхтэй.
- 3.4 Энэ журмын 3.3-т заасны дагуу аудитор оос гомдол гаргасан бол дотоод аудитор тухайн мэдээлэл баримт бичгийг биечлэн хариуцаж гарган, толилуулах үүрэг хүлээнэ.

Дөрөв. Аудиторын дүгнэлтийг хүлээн авах

- 4.1 Аудитын ажил дууссаны дараа аудитор санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон ТУЗ-д зориулан бэлдсэн зөвлөмжийн хамт хүлээлгэн өгнө.
- 4.2 Дүгнэлт зөвлөмжтэй дотоод аудитор болон холбогдох газар нэгжийн удирдлага танилцаж, өөрийн саналыг бэлдээд гүйцэтгэх захиралд танилцуулна.
- 4.3 Гүйцэтгэх захирал нь аудитын дүгнэлтийн талаар тайлбар өгөхийг шаардах эрхтэй.
- 4.4 Аудитын дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол Сангийн яам, ММНБИ-д гомдол гаргах эрхтэй.
- 4.5 Аудитын дүгнэлт зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн бол зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжүүлнэ.

Тав. Хөндлөнгийн аудитын үйлчилгээтэй холбогдон дотоод аудиторын гүйцэтгэх үүрэг

- 5.1 Дотоод аудитор нь хөндлөнгийн аудитын үйлчилгээний чанарыг шалгалт дууссаны эцэст үнэлж дүгнэх, хөндлөнгийн аудиторыг дахин үргэлжлүүлэн сонгох эсвэл гэрээг цуцлах асуудлаар санал зөвлөмж бэлтгэн ТУЗ-ийн Аудитын хорооны хуралд оруулдаг байх;
- 5.2 Гүйцэтгэх удирдлага, дотоод аудитор хамтран тухайн жилийн аудитын ажлын төлөвлөгөөг боловсруулах бөгөөд үүнд компанийн тухайн үеийн нөхцөл байдал, хууль тогтоомжоор болон гэрээгээр хүлээсэн үүрэг болон тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт, хөндлөнгийн аудиторын зөвлөмжийг харгалзан үздэг байх;
- 5.3 Аудитын ажиллагаанд хязгаарлалт тавих, мэдээлэлд чөлөөтэй нэвтрэх боломжийг хязгаарлах, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхгүй байх зэргээр аудиторын хэвийн үйл ажиллагаанд ямар нэг саад бэрхшээл учирсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх тогтолцоо бүрдүүлэх;
- 5.4 Хөндлөнгийн аудитын шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүнийг засч залруулах талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх;

- 5.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр хөндлөнгийн аудиторт асуулт тавьж, хариулт авах боломжийг хангах;
- 5.6 Компанийн санхүүгийн тайланг СТОУС, Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан журам, компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого зэрэгт нийцүүлэн бэлтгэх нөхцөлийг хангах ба компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон хэвшсэн практик нь СТОУС-д хэр нийцтэй байгаа талаар үнэлэлт дүгнэлт хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг анхаарч, холбогдох арга хэмжээ авдаг байх;
- 5.7 Хөндлөнгийн аудитороор аудитын бус үйлчилгээ, даалгавар гүйцэтгүүлэхэд компаниас баримтлах бодлогыг боловсруулах ба шаардлагатай тохиолдолд бусад баталгаажуулах ажил гүйцэтгүүлэх, аудитын бус үйлчилгээ авахаар бол урьдчилан ТУЗ-өөс зөвшөөрөл авдаг байх тогтолцоог бий болгох;
- 5.8 Хөндлөнгийн аудитын зүгээс компанид бусад үйлчилгээ үзүүлэх, аудитын байгууллагыг заавал сольдог байх талаар АОУС болон Аудитын тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах.

6. Хариуцлага

- 6.1 Энэ журамд заасны дагуу аудитын байгууллагыг сонгоогүй тохиолдолд компанийн эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 11.1.3-т заасан хариуцлага хүлээнэ.